



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/764

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ховд аймгийн Дуут суманд инженерийн хийцтэй худаг, угаалгын ванн барих ажлыг хүлээн авах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Баярсүх	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Жамбалдорж	- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн
	С.Ганзориг	- Дуут сумын Засаг дарга
	Э.Гансүх	- Хүнс, хөдөө аж ахуйн газрын бэлчээр усан хангамж хариуцсан мэргэжилтэн
	К.Долгормаа	- Дуут сумын Засаг даргын Тамгын газрын Мал эмнэлэгийн тасгийн дарга
	У.Батзаяа	- “Эвлэл” ХХК-ны захирал
	С.Батдорж	- Аймгийн архивын тасгийн эрхлэгч
	Т.Бямбажаргал	- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Ц.Пүрэвсүрэн	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Инженерийн хийцтэй худаг гаргах, угаалгын ванн барих ажлыг хүлээн авахтай холбогдон гарах зардлыг тухайн төслийн техник хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3.Тухайн ажлыг төсвийн дагуу шалгаж, норм нормативыг баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг Улсын комиссын дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН